



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/115

Мандалговь

“Эхний эхэн” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах багц-2 (Дундговь, Дэрэн, Хулд, Луус, Өлзийт сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эхний эхэн” ХХК-тай 180,351,998 (нэг зуун наян сая гурван зуун тавин нэгэн мянга есөн зуун ерэн найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Стандартын дагуу Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах (Дундговь, Дэрэн, Хулд, Луус, Өлзийт сум) ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Эхний эхэн” ХХК-ийн гүйцэтгэх захирал (О.Хүүхэнбаатар)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Дэрэн сумын Засаг дарга (Н.Мядагмаа), Хулд сумын Засаг дарга (Ч.Зоригтбаатар), Луус сумын Засаг дарга (Б.Баттулга) Өлзийт сумын Засаг дарга (А.Эрдэнэбат) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060518